



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН
ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

2017 он



АУДИТЫН КОД: САГ-2017/25/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл

Утас: 261740 Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Ахлах аудитор Ж.Батсайхан

Утас: 261885 Цахим хаяг: batsaikhanj@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.7	Шилэн дансны мэдээлэл	9
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	9
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	9
2.9.1	Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.9.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	10
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	11
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	12
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	12
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	13
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3	Менежментийн захидал	15
3.1	Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	16
3.2	Санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан өглөг, авлагын талаар	17
4	Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	18
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	18
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	19
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	22
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	24

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

1 Аудитын гэрчилгээ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017. 04. 25 № 750
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн сайд Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kheregl\Yawsan_Bichig\2017\0425SAG7.Docx

079159

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Зөрчилгүй санал дүгнэлт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 15-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Батсайхан хариуцаж хэрэгжүүлэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 1-1/1385 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хууль зүй, дотоод хэргийн сайд Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар тогтоосон доор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх асуудлыг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Эрх зүйн шинэтгэлийн бодлого;
- хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл, эрх зүйн сургалт, сурталчилгаа, судалгаа;
- эрх зүйн туслалцаа;
- улсын хил хамгааллын асуудал;
- цагдаа, нийгмийн дэг журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх асуудал;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа;
- Засгийн газраас шүүх, прокурорын байгууллага, хуульчдын олон нийтийн байгууллагатай харилцах асуудал;
- төрөөс сүм хийдтэй харилцах асуудал;
- иргэний харьяалал, цагаачлалын асуудал;
- энгийн зэргийн виз, Монгол Улсад орох, гарах, оршин суух гадаадын иргэний асуудал;
- төрийн захиргааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналт;
- иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл;
- хэвлэл, мэдээллийн хэрэгслийн бүртгэл;
- оюуны өмч, патент, зохиогчийн эрхийн асуудал;
- архивын талаар төрөөс баримтлах бодлого зэрэг болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайд дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд явуулсан үйл ажиллагаа, түүний үр дүнгийн талаар хураангуйлан тэмдэглэв.

Хууль зүй, дотоод хэргийн яам тайлант хугацаанд төлөвлөсөн ажлаа дараах чиглэлээр дэлгэрэнгүй тайлагнасан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх хүрээний асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор 480 арга хэмжээ төлөвлөж, 98.1 хувийн биелэлттэй байна.

- Эрх зүйн бодлого, стратегийн төлөвлөлт;
- Бодлогын удирдамжаар хангах үйл ажиллагаа;
- Төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах ажиллагаа;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, санхүүгийн зохицуулалтаар хангах үйл ажиллагаа;
- Гэрээ, эрх зүй, хамтын ажиллагаа;
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа;

- Эрх зүйн шинэтгэл, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт – шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, дотоод аудит хийх үйл ажиллагаа;

Тухайлбал төлөвлөсөн зарим арга хэмжээний биелэлтийг дараах байдлаар товчоолов.
Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 56 арга хэмжээний биелэлт 88.4 хувь;
- Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд 107 арга хэмжээг төлөвлөж, биелэлт 96.9 хувь;
- Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд 35 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 95.1 хувь;
- Засгийн газрын тогтоолоор баталсан Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 16 хөтөлбөрийг хяналтад авч, үүнээс 6 хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам толгойлон хэрэгжүүлжээ. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд нийт 362 арга хэмжээ төлөвлөж, биелэлт 92.3 хувь;
- Хууль зүй, дотоод хэргийн яамны 2016 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 513 арга хэмжээний биелэлт 92.3 хувь байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитын чиглэл тус бүрийн уламжлалт болон хяналтын эрсдэлийг төлөвлөсөн хэмжээнд үнэлснээс гадна Хууль зүй, дотоод хэргийн яамны зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, СТАУС-т байгаа аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 8 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт,

журам зааврын зарим зүйл, заалттай нийцэхгүй болсон тул уг баримт бичигт дараах чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байна. Үүнд:

- Эрхлэх асуудлын хүрээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн шинэчлэлтэй холбоотой асуудал;
- санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал;
- нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагаатай холбоотой бодлого зэрэг болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг “Э-тайлан” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит хийх чиг үүрэг гүйцэтгэж байна.

Тус газар Монгол Улсад шударга ёс, хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлж, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх зорилгын дор 2016 онд “Эрсдэлд суурилсан дотоод аудитыг хийж, зөрчлийг арилгаж, заавар чиглэл, зөвлөмж өгөх” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Дотоод аудитын ажлын зарим үзүүлэлт

№	ҮЗҮҮЛЭЛТ	ДҮН
1	Хийхээр төлөвлөсөн шалгалтын тоо	10
2	Гүйцэтгэсэн шалгалтын тоо	10
3	Шалгалтад хамрагдсан байгууллага, нэгжийн тоо	7
4	Илрүүлсэн нийт зөрчлийн	Тоо
		Дүн (мян.төг)
5	Өгсөн зөвлөмжийн	Тоо
		Дүн (мян.төг)
6	Тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын	Тоо
		Дүн (мян.төг)

Дээрх шалгалтын явцад нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичгийг боловсруулан батлаж үйл ажиллагаандаа мөрдлөг болгоогүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өр, авлагыг бүрэн баталгаажуулаагүй, шилэн дансны мэдээлэл дутуу оруулсан зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд тухай бүр хугацаатай зөвлөмж өгч ажиллажээ.

Сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудитыг цаг тухайд нь хийж зөрчил дахин гаргахгүй байх тал дээр анхаарч ажилласны дүнд өмнөх зөвлөмжийн биелэлтийн хувь өссөн байна.

Энэ нь дотоод аудитын ажлын үр дүн бөгөөд системийн хэмжээгээр эрсдэл бага, дотоод хяналт үр нөлөөтэйг харуулж байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад 2016 онд хэрэгжүүлэх 13 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Дээрх хуулиар Хууль зүй, дотоод хэргийн сайдад батлагдсан хөтөлбөрөө хэрэгжүүлэхэд зориулж нийт зардалд 413,828.4 сая төгрөг, төвлөрүүлэх орлогын хэмжээг 63,554.6 сая төгрөгөөр баталжээ.

Төсөвт зардлын гүйцэтгэл нийт дүнгээрээ 97.7 хувь буюу 9,274.5 сая төгрөгөөр хэмнэлттэй байна. Үүнээс Урсгал зардалд 398,302.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 389,194.3 сая төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 9,108.1 сая төгрөгөөр хэмнэжээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсөвт зардлын ерөнхий ангиллаар хэтэрсэн зардал алга байна.

Засгийн газрын 2016 оны “Засгийн газрын агентлагийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 4 дүгээр тогтоолоор Тахарын ерөнхий газрыг татан буулгаж чиг үүргийг Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт, Бүртгэл, статистикийн ерөнхий газрын нэрийг өөрчлөн Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар болгон Үндэсний статистикийн газрыг Шадар сайдын ажлын албанд шилжүүлж, Оюуны өмчийн газрыг Улсын

Их Хурлын Тамгын газраас Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд нэгтгэсэнтэй холбогдуулан хөтөлбөр, арга хэмжээний биелэлтийг 11 хөтөлбөрт хамруулан тайлагнажээ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад 2016 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, түүний хүрсэн үр дүнг хөтөлбөр, зориулалт бүрээр гаргаж, баримтжуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Хууль зүй, дотоод хэргийн сайд төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (Бүтэн жилээр);
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр, Хагас жилээр, Улирал бүр, Сар бүр);
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр);
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (Тухай бүр);
7. Санхүүгийн тайлан (Бүтэн жилээр, Хагас жилээр);
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (Бүтэн жилээр);
9. Байгууллагын батлагдсан төсөв (Бүтэн жилээр) зэрэг болно.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит хийхэд Хууль зүй, дотоод хэргийн яамтай холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 218 нэгж, байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын санал дүгнэлт гаргахаас Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар 24 байгууллагад итгэл үзүүлж, 50 байгууллага, нэгжид түүвэр хэлбэрээр аудит хийж, 144 байгууллага, нэгжид санхүүгийн тайлангийн аудит хийж санал дүгнэлт гаргасан байна.

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нарын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийх явцад нийт 7,622.6 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсний дотор 273 зөвлөмж, 841.1 сая төгрөгийн 66 албан шаардлага хүргүүлж, 121.1 сая төгрөгийн 25 төлбөрийн акт тогтоосон байна.

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон төлбөрийн акт, залруулгын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг нэгж тус бүрээр гаргаж, ажлын баримт материалд хавсаргав.

Шийдвэрлэсэн нь:

Төсвийн шууд захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх

2.9.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад төлөвлөсөн горим сорилыг бүрэн хэрэгжүүлсэн.

Аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд нэгтгэдэг 6 байгууллага, нэгжид түүвэр хэлбэрээр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд аудитын явцад нийт 168.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 18 зөвлөмжийг 4 байгууллагад хүргүүлэхээр шийдвэрлэв.

Эдгээр зөвлөмжийг нэгтгэж, ажлын баримт материалд хавсарган байгууллага тус бүрт хүргүүлэв.

Дээрх байгууллагуудад хийсэн аудитын явцад илэрсэн нийтлэг алдаа, зөрчлийг дараах байдлаар хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Хөрөнгө материал худалдан авсан ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа шууд зардалд бичдэг, зарим зардлын гүйлгээг зөв ангилж бүртгэдэггүй, гарын үсэг, баталгаажуулалт дутуу буюу бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийдэг;
- урамшуулал, ур чадварын нэмэгдлийг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлж, хавтгайруулан олгодог;
- томилолтын зардлын тооцоог бүрэн хийдэггүй, томилолтын удирдамж, тайлан ажлын гүйцэтгэлийн талаарх баримт материал байдаггүй;
- гэрээт ажлын гүйцэтгэлийг зохих журмын дагуу баримтжуулдаггүй, гүйцэтгэлийг дүгнэж, баталгаажуулаагүй байхад санхүүжилтийг бүрэн олгож, гэрээт ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг сулруулдаг зэрэг болно.

Шийдвэрлэсэн нь:

Түүврээр аудитад хамрагдсан байгууллагын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны 2016 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайланд тусгасан 29,621.7 сая төгрөгийн Засгийн газрын байгууллагад өгөх өглөгийг Сангийн яам 28,726.0 сая төгрөгөөр санхүүгийн тайланд тусгасан байна.

Эдгээр байгууллага санхүүгийн тайлан дахь 895.7 сая төгрөгийн зөрүүтэй өглөг, авлагыг шийдвэрлэлгүй удаашруулсан нь холбогдох ажилтнууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлж, ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрүүтэй авлага, өглөгийг холбогдох баримтаар баталгаажуулан шийдвэрлэх зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын Үндэсний аудитын газарт ирүүлсэн 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь зарим үзүүлэлт аудит хийх явцад удаа дараа өөрчлөгдөж, эцэслэхгүй удааширч, аудитад хүндрэл учруулав.

Энэ нь Сангийн яамны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нэгтгэдэг “Э-Тайлан” програм хангамж хэвийн ажиллаагүй, төсвийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавих зорилго бүхий “Free balance” програм дахь төсвийн санхүүжилт, гүйцэтгэлтэй холбоотой тооцоо нийлэх, залруулга хийх, тэдгээрийг баталгаажуулах ажлыг санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргахаас өмнө хийлгүй сунжирсантай холбоотой байна. Энэ байдал нь олон байгууллага санхүүгийн тайландаа нэгтгэдэг салбарын хувьд санхүүгийн нэгтгэсэн тайланг үнэн зөв гаргах боломжгүй эрсдэлтэй болгож байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 64 дүгээр тогтоолоор Банкны өр барагдуулах газрын чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албанд шилжүүлсний дагуу Банкны өр барагдуулах газраас 2009 онд татан буугдсан зургаан банк, өрхийн амьжиргааг дээшлүүлэх төслийн 28.0 тэрбум болон хөдөө орон нутгийн зээлийн 5.0 тэрбум, нийт 33.0 тэрбум төгрөгийн зээлийн материалыг тус албанд хүлээлгэн өгсөн байна.

Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба шүүхийн шийдвэрийн дагуу 2016 онд 104.7 сая төгрөгийн авлага барагдуулж, 2016 оны жилийн эцсийн байдлаар банкны өр барагдуулахтай холбоотой 29,621.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Банкны өр барагдуулах газраас 2009 онд тус албанд хүлээлгэн өгсөн 6787 зээлдэгчид холбогдох 28.0 тэрбум төгрөгийн зээлээс шүүхийн шийдвэргүй 3074, зээлийн материалгүй /зээлийн материал байхгүй, зөвхөн жагсаалт байгаа, жагсаалтад овог тодорхойгүй, регистрийн дугаарын бүртгэлгүй/ 330, дууссан 819, зээлдэгч нь нас барсан 227, шүүхийн шийдвэрээр

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

хэрэгсэхгүй болсон 21, нийт 5683 зээлдэгчид холбогдох 16.9 тэрбум төгрөгийн зээлийн материалд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах боломжгүй байна.

Эдгээр зээлийн материал нь анх гэрээ байгуулж, зээл олгосноос хойш 20-25 жил болсон зээлийн материалууд бөгөөд шаардах эрхийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул нэхэмжлэх эрх бүхий этгээд шинээр нэхэмжлэл гарган шүүхийн шийдвэр гаргуулах боломжгүй нөхцөл байдал үүсээд байгааг хэрхэн шийдвэрлэх талаар холбогдох газруудад ханддаг боловч шийдвэрлээгүй байна.

Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны санхүүгийн тайланд тусгасан 29.6 тэрбум төгрөгийн авлагаас 5683 зээлдэгчид холбогдох 16.9 тэрбум төгрөгийн зээлийн авлага нягтлан бодох бүртгэл, тайлагналын хувьд авлагаар хүлээн зөвшөөрөх шаардлагыг бүрэн хангахгүй байгаа тул холбогдох байгууллага, албан тушаалтнууд анхааралдаа авах нь зүйтэй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Аудитын явцад гүйцэтгэсэн горим сорил, зарим аудитын чиглэлд өгсөн эрсдэлийн үнэлгээ зэргээс үзэхэд дараах чиглэлээр нарийвчилсан горим сорил төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, түүний хэрэгжилтийн байдалд системийн хэмжээнд нэгтгэсэн дүгнэлт гаргах;
- нягтлан бодох бүртгэлийн програм хангамжийн ашиглалт, мэдээллийн аюулгүй ажиллагааны талаар нэгдсэн дүгнэлт гаргах.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЙН НЭГТГЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар системийн хэмжээнд нийт 7,744.2 сая төгрөгийн алдаа, зөрчил нэгтгэж, баталгаажуулав.

Дээрх зөрчлийн талаарх мэдээллийг дараах байдлаар ангилан үзүүлэв.

/сая.төг/

№	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн	Алдаа, зөрчлийн ангилал												Аудитын явцад илэрсэн нийт залруулаагүй алдаа, зөрчлийн дүн	
		Аудитаар өгсөн зөвлөмж		Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн залруулга		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Албан тушаалт анд хариуцл ага тооцуулах санал		Бусад			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
1	Төсвийн шууд захирагч	26	168.9	-	-	-	-	-	-	-	-	-	-	25	168.9
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	238	13,534.3	98	14,273.9	24	90.7	62	681.6	2	5.6	9	3,4	335	5,959.0
3	Төрийн өмчит аж ахуйн нэгж	28	1,426.3	7	54.8	1	30.4	4	159.5	-	-	-	-	33	1,616.3
	Бүгд дүн	292	15,129.6	105	14,328.8	25	121.1	66	841.1	2	5.6	9	3.4	393	7,744.2

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2015 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд Үндэсний аудитын газраас хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт – шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хяналт тавьж ажилласан бөгөөд зөвлөмжийн биелэлт 2016 оны жилийн эцсийн байдлаар 91.0 хувьтай байна. Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 1-3/743 дугаар албан бичгээр ирүүлсэн болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 476,362,424.5 сая төгрөг бөгөөд түүний 2.0 хувь 9,527.2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулав.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төрийн аудитын байгууллага Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн 218 байгууллага, нэгжид санхүүгийн тайлангийн аудит хийсэн байдлыг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн
аудитад хамрагдсан хэлбэр, авсан санал дүгнэлт

№	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн ангилал	Санхүүгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулах байгууллага					Аудитын санал дүгнэлтийн төрөл				
		Аудитад хамрагдвал зохих	Үүнээс				Бүгд тоо	Үүнээс:			
			Аудитад хамрагдаж, дүгнэлт гаргуулсан	Түүвэрт хамруулсан	Итгэл үзүүлсэн	Аудит хийгдээгүй		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	санал дүгнэлт гаргахаас тагталзсан
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	7	2	5			2	2			
2	ТТЗ	201	132	46	23		158	156	2		
3	ТХН										
4	ТӨААН	10	10				10	7	3		
	Бүгд дүн	218	144	51	23		170	165	5	0	0

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-т тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг Та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс болон Хяналт – Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

3.1 Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд аудит хийхэд илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нарын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийх явцад нийт 7,622.6 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчил илэрсний дотор 273 зөвлөмж, 841.1 сая төгрөгийн 66 албан шаардлага хүргүүлж, 121.1 сая төгрөгийн 25 төлбөрийн акт тогтоосон байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагч нарын 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын явцад өгсөн зөвлөмж, илэрсэн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг нэгтгэсэн байдлаар гаргаж, үнэлэлт өгөх

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

**3.2 Санхүүгийн тайланд зөрүүтэй
тусгасан өглөг, авлагын талаар**

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны 2016 оны жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайланд тусгасан 29,621.7 сая төгрөгийн Засгийн газрын байгууллагад өгөх өглөгийг Сангийн яам 28,726.0 сая төгрөгөөр санхүүгийн тайланд тусгасан байна.

Эдгээр байгууллага санхүүгийн тайлан дахь 895.7 сая төгрөгийн зөрүүтэй өглөг, авлагыг шийдвэрлэлгүй удаашруулсан нь холбогдох ажилтнууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүйтэй холбоотой байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

ҮАГ-ын зөвлөмж

Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын алба санхүүгийн тайланд зөрүүтэй тусгасан өглөгийг холбогдох баримтаар нотлон Сангийн яамтай тооцоо нийлж, баталгаажуулах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	166,856,448.3	153,186,986.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,998,374.9	11,621,390.6
33	АВЛАГА	47,429,313.3	48,755,359.5
34	УРЬДЧИЛГАА	2,102,892.1	2,404,766.8
35	БАРАА МАТЕРИАЛ	106,063,959.5	86,392,302.8
36	НӨӨЦИЙН БАРАА	261,908.4	4,013,167.3
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	334,146,813.9	357,649,689.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	334,146,813.9	357,649,689.0
392	Биет хөрөнгө	331,297,166.9	354,174,703.9
393	Биет бус хөрөнгө	2,849,647.0	1,912,924.0
394	Бусад хөрөнгө	-	1,562,061.1
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	501,003,262.2	510,836,675.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	77,373,430.3	78,103,007.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	77,373,430.3	78,101,007.0
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,000.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	423,629,831.9	432,733,668.8
51	Засгийн газрын хувь оролцоо	423,629,831.9	432,733,668.8
511	Засгийн газрын оруулсан капитал	205,125,098.0	216,902,127.0
512	Хуримтлагдсан үр дүн	157,707,045.3	157,224,137.7
51210	Өмнөх үеийн үр дүн	137,762,508.7	136,537,821.4
51220	Тайлант үеийн үр дүн	19,944,536.7	20,686,316.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	60,797,688.6	58,607,404.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	501,003,262.2	510,836,675.9

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	454,641,673.2	496,764,722.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	128,387.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	-	128,387.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	66,210,241.4	79,152,918.8
120	Нийтлэг татварын бус орлого	66,185,693.8	78,989,636.6
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	24,547.6	163,282.2
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
124	Зээлийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	388,431,431.8	417,483,415.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	434,755,399.2	464,879,805.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	434,622,870.8	464,629,805.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	382,987,796.5	411,671,303.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,012,668.7	250,328,516.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9,795,531.6	9,642,439.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,814,589.0	13,538,113.8
2104	Хангамж, бараа материалын зардал	20,098,162.0	34,260,953.9
2105	Нормативт зардал	28,735,774.7	29,851,616.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,225,106.1	5,995,633.7
2107	Томилолт, зочны зардал	1,464,737.9	1,426,245.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,778,921.6	24,989,300.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,062,304.8	41,638,483.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,634,116.8	52,958,502.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	39,143.7	12,601,282.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,087,561.2	26,199,573.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	21,701,930.2	7,535,919.2
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,383,550.5	5,569,991.6

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	421,931.2	1,051,736.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	132,528.4	250,000.0
2200	Дотоод эх үүсвэрээр	132,528.4	250,000.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	19,886,274.0	31,884,916.6
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,835,489.6	284,018.5
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,777,227.0	11,482,618.8
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	58,262.6	-11,198,600.3
5	НИЙТ ҮР ДҮН	19,944,536.6	20,686,316.3

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНИЙ НИЙТ ДҮН	ЦӨӨНХИЙН ХУВЬ ОРОЛЦОО	НИЙТ ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧ
3	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	403,895,562.7		403,895,562.7
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	12,286,846.1		12,286,846.1
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	416,182,408.8		416,182,408.8
6	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(9,250.0)		(9,250.0)
7	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(12,487,863.5)		(12,487,863.5)
8	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
9	Тайлант үеийн үр дүн	19,944,536.7		19,944,536.7
10	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	423,629,831.9		423,629,831.9
11	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	423,629,831.9		423,629,831.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(9,187,734.4)		(9,187,734.4)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	414,442,097.5		414,442,097.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(2,222,561.8)		(2,222,561.8)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(172,183.2)		(172,183.2)
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-
18	Тайлант үеийн үр дүн	20,686,316.3		20,686,316.3
19	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	432,733,668.8		432,733,668.8

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4.4 Аудит хийгдсэн МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	527,888,712.4	548,085,594.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	932,901.4
118	Бусад татвар, төлбөр, хураамж	0.0	932,901.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	138,126,802.4	132,746,507.5
120	Нийтлэг татварын бус орлого	138,126,802.4	132,746,507.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	389,761,909.9	414,406,185.4
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	370,909,849.8	390,656,922.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	16,139,603.1	21,034,396.3
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,142,500.0	1,124,510.0
1330	Төсвийн захирагчдаас	142,208.6	0
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,427,748.5	1,590,356.4
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	491,633,598.4	521,619,415.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	491,633,598.4	521,619,415.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	436,635,554.8	455,755,566.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,572,363.6	251,183,666.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,737,639.0	10,591,458.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,293,121.1	15,111,240.6
2104	Хангамж, бараа материалын зардал	17,081,420.1	24,120,380.5
2105	Нормативт зардал	27,333,551.6	29,925,864.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,952,209.5	7,759,927.1
2107	Томилолт, зочны зардал	1,397,441.5	1,618,325.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,210,987.0	33,336,466.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,056,821.5	82,108,237.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,998,043.7	65,863,849.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	50,932.5	22,477,856.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,984,384.6	27,635,184.1
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	24,060,953.2	5,633,438.4

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,563,010.2	8,035,542.2
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,338,763.3	2,081,828.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	36,255,113.9	26,466,178.3
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	0.0	60.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	35,797,505.9	24,207,414.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	35,797,505.9	24,207,414.2
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-35,797,505.9	-24,207,354.2
14	Бусад эх үүсвэр	0.0	304,066.0
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	7,920.0	1,916,428.5
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-7,920.0	-1,939,874.5
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	449,688.1	623,015.7
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,548,686.8	10,998,374.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,998,374.9	11,621,390.6

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ҮЗҮҮЛЭЛТ	ТАЙЛАНТ ОНЫ		ЗӨРҮҮ	ХУВЬ
		БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	413,828,350.2	404,553,831.2	9,274,519.0	97.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	398,302,350.2	389,194,266.3	9,108,083.8	97.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,733,019.2	361,302,881.7	8,430,137.5	97.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	248,211,823.1	247,359,888.2	851,934.9	99.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,566,719.7	10,198,867.1	367,852.6	96.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,236,238.9	14,113,369.0	1,122,869.8	92.6
2104	Хангамж, бараа материалын зардал	16,843,916.2	16,568,555.6	275,360.6	98.4
2105	Нормативт зардал	29,784,292.9	29,570,890.2	213,402.7	99.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,274,307.0	7,916,381.0	357,926.0	95.7
2107	Томилолт, зочны зардал	1,333,258.9	1,229,658.0	103,600.9	92.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,375,883.9	27,154,095.2	4,221,788.7	86.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,106,578.6	7,191,177.4	915,401.2	88.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,569,331.0	27,891,384.7	677,946.3	97.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	512,181.8	372,546.0	139,635.8	72.7
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	452,966.3	331,672.6	121,293.7	73.2
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	59,215.5	40,873.4	18,342.1	69.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,057,149.2	27,518,838.7	538,310.5	98.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	15,526,000.0	15,359,564.8	166,435.2	98.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(22,177,100.0)	-	(22,177,100.0)	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	391,651,250.2	405,261,295.0	(13,610,044.8)	103.5
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	395,660,096.3	389,151,594.8	6,508,501.5	98.4
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	962,500.0	962,500.0	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	17,205,753.9	15,147,200.2	2,058,553.7	88.0
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(22,177,100.0)	-	(22,177,100.0)	0.0

Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын
2016 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	17,066.7	(17,066.7)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,258.5	(3,258.5)	